



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/508

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын нийтийн эзэмшлийн талбай, явган болон авто зам арчлалтын зардалд 30 000 000 (гучин сая) төгрөгийн эрхийг шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгийг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, мэргэжлийн байгууллагын оролцоог ханган ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээнд батлагдсан "Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар" зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010484